

ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГААС АЛБАН БУС-НАСАН ТУРШИЙН БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН ЗАХИРАЛТАЙ БАЙГУУЛАХ 2024 ОНЫ ХАРИУЦЛАГЫН ГЭРЭЭ

2024 оны дүгээр
сарын-ны өдөр

№

Улаанбаатар
хот

Нэг. Нийтлэг үндэслэл

1.1 Энэхүү гэрээний зорилго нь Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, Хан-Уул дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх, шударга, ил тод, хариуцлагатай, иргэн төвтэй төрийн албыг төлөвшүүлж, ажлын хариуцлага, сахилга, дэг журмыг чангатгаж, иргэдэд хүргэх төрийн болон нийгмийн үйлчилгээний чанар, үр ашгийг дээшлүүлэх, хуулиар хүлээсэн чиг үүргийн хүрээнд хүлээх үүрэг, хариуцлагыг тодорхой болгож, эцсийн үр дүнг үнэлж, гэрээг дүгнэхтэй холбогдох харилцааг зохицуулахад оршино.

1.2 Нэг талаас Хан-Уул дүүргийн Засаг дарга Жуковын Алдаржавхлан, нөгөө талаас Албан бус-Насан туршийн боловсролын төвийн захирал Таншийгийн Рэгзэдмаа нар 2024 оны 01 дүгээр сарын 02-ны өдрөөс 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийг дуустал нэг жилийн хугацаатайгаар энэхүү гэрээг байгуулж, 2 хувь үйлдэв.

1.3 Энэхүү гэрээтэй холбоотой бусад асуудлыг Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон бусад хууль, тогтоомжоор зохицуулна.

Хоёр. Төсвийн ерөнхийлөн захирагчийн эрх, үүрэг

2.1 Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 62 дугаар зүйлийн 62.1 дэх хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.2 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчтай байгуулсан гэрээний дагуу Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1 дэх хэсэгт заасан чиг үүргийг хэрэгжүүлэх үйл ажиллагааг хариуцан зохион байгуулна.

2.3 Дүүргийн төсвийн орлого бүрдүүлэгч байгууллагуудыг удирдлага арга зүйгээр хангаж, дүүргийн хэмжээнд санхүү, төсөв, татварын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх, дүүргийн төсвийн орлогын бүрдүүлэлтийг хангах ажлыг зохион байгуулна.

2.4 Нутгийн захиргааны бүх шатны байгууллагын ажлын уялдаа холбоог хангаж, төрөөс иргэдэд үзүүлэх үйлчилгээний чанар хүртээмжийг сайжруулан үйлчилгээний шуурхай, чирэгдэлгүй байх нөхцөлийг бүрдүүлж, хариуцлагыг сайжруулах чиглэлээр зохих арга хэмжээг хэрэгжүүлнэ.

2.5 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлд тусгагдсан зорилтууд, Нийслэлийн Хөгжлийн 2024 оны төлөвлөгөө, Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөний хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж, хэрэгжилтийг хангах ажлыг нэгдсэн удирдлагаар хангана.

2.6 Төрийн албаны тухай хуулийн хэрэгжилтийг хангаж, төрийн жинхэнэ албыг тогтвор суурьшилтай, үр бүтээлтэй ажиллуулах, төрийн албанд сахилга, хариуцлагыг чангатгах арга хэмжээ авна.

2.7 Төсвийн зардлыг хэмнэх, төсвийн зарлагын үр өгөөжийг нэмэгдүүлэх, улс, орон нутгийн төсөв болон бусад эх үүсвэрээр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний чанар, гүйцэтгэлд тавих хяналтыг сайжруулж, удирдлага, зохицуулалтаар хангана.

2.8 Төрийн худалдан авах ажиллагаанд Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах тухай хуулийг хэрэгжүүлэн, нутгийн захиргааны байгууллагуудад тогтмол зөвлөмж, чиглэл өгч, сургалт, мэдээллээр хангаж ажиллана.

2.9 Дүүргийн Засаг дарга нь дүүрэг дэх улсын төсвийн байгууллагын санхүүжилтийг Сангийн сайдын баталсан төсвийн сар, улирлын хуваарийн дагуу Дүүргийн төрийн сан дахь дансаар дамжуулан олгоно.

2.10 Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2 дахь хэсэгт заасан бүрэн эрхийг хэрэгжүүлнэ.

2.11 Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт заасан бүрэн эрхийн хэрэгжилтэд хяналт тавина.

2.12 Тухайн төрийн байгууллага болон эрх шилжүүлсний үндсэн дээр бусад байгууллагын хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээний санхүүжилтийг хуулийн хугацаанд нь олгоно.

Гурав. Төсвийн шууд захирагчийн эрх, үүрэг

3.1 Хууль, тогтоомжийн хүрээнд:

3.1.1 Хууль, тогтоомж, тогтоол шийдвэрийн хэрэгжилтийг хангах ажлыг зохион байгуулж, хэрэгжилт, үр дүнг журмын дагуу тайлагнах;

3.1.2 Монгол хэлний тухай хууль, холбогдох стандартыг байгууллагын хэмжээнд мөрдүүлэх, төрийн албан хаагчдад үндэсний бичгийн сургалтыг Хэлний бодлогын үндэсний зөвлөл болон бусад холбогдох байгууллагуудтай хамтран зохион байгуулах;

3.1.3 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.3-т заасан чиг үүргийг хэрэгжүүлэх (сургуулийн гадна байгаа хүүхэд болон сургууль завсардсан хүүхэд, залуучуудад боловсрол нөхөн олгох, ажлыг зохион байгуулах);

3.1.4 Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.5.8-д заасан чиг үүргийг хэрэгжүүлэх (бүх нийтийн соёлын боловсрол арга хэмжээг хэрэгжүүлэх ХЗДХ, ХНХ, БШУ, ЦХХХ, ЭМ, Соёлын сайд, НЗД нарын 2023.12.05-ны өдрийн хамтарсан албан даалгаврын хэрэгжилтийг ханган ажиллах);

3.1.5 Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуйн тухай хууль, Хөгжлийн бэрхшээлтэй хүний тухай хууль, Жендэрийн эрх тэгш байдлыг хангах тухай хуулийн хэрэгжилтийг ханган, тайлагнан ажиллах;

3.1.6 Байгууллагын төсвийн орлого, зарлага, тайлангийн бүх мэдээллийг олон нийтэд ил тод байхаар Шилэн дансны тухай хуулийг хэрэгжүүлж ажиллах;

3.1.7 Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсэгт заасан бүрэн

эрхийг хэрэгжүүлэх; **(Төсвийн шууд захирагч нарт хамаарна)**

3.1.8 Нийтийн мэдээллийн ил тод байдлыг хангах тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалтын дагуу “Үйлчилгээний төрөл, шийдвэрлэх журам, хугацаа, бүрдүүлэх баримт бичиг, түүний загвар, төлбөр, хураамж, зохицуулалтын үйлчилгээний хөлсний хэмжээ, төлбөр төлөх дансны мэдээлэл”, мөн 8.6.22, 8.13, 8.14-т заасан мэдээллүүдийг дүүргийн цахим хуудасд хуульд заасан хугацаанд байршуулах, өөрчлөгдсөн тохиолдолд 8.11-д заасны дагуу 3 хоногийн дотор мэдээллийг шинэчлэх;

3.1.9 Худалдан авах ажиллагааг холбогдох хууль тогтоомжийн дагуу Төрийн худалдан авах ажиллагааны цахим систем (www.tender.gov.mn)-ээр шуурхай зохион байгуулж, үр дүнг тухай бүр цахим системд байршуулан, Сангийн сайдын 2019 оны 132 дугаар тушаалаар батлагдсан “Тендер шалгаруулалтын материалыг тухайн тендерт оролцогчдод ил болгох журам”-ыг үйл ажиллагаандаа мөрдлөг болгон ажиллах; **(Төсвийн шууд захирагч нарт хамаарна)**

3.1.10 Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмын 2.7-д заасны дагуу байгууллагын гүйцэтгэлийн төлөвлөгөөг тухайн шатны Засаг даргын Тамгын газрын даргын саналыг үндэслэн өөрийн харьяалах төсвийн шууд захирагч хянан тухайн жилийн 01 дүгээр сарын 15-ны өдрийн дотор цахим системд баталгаажуулах;

3.1.11 Засгийн газрын 2023 оны 301 дүгээр тогтоолын хавсралтаар батлагдсан Төрийн жинхэнэ албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөөг боловсруулж батлах, ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшлийн түвшинг үнэлэх журмын 5.2-т заасны дагуу байгууллагын төлөвлөгөөний гүйцэтгэлийг үнэлэхдээ Засаг даргын Тамгын газрын даргын саналыг тусгах;

3.2 Төсвийн хөрөнгө оруулалтын хүрээнд:

3.2.1 Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны тухай хууль болон Шилэн дансны тухай хуульд заасан төсөв, санхүүгийн ил тод байдлыг хангаж, шилэн дансны цахим хуудсанд тавигдах мэдээ, мэдээллийн үнэн зөв байдлыг хариуцан ажиллах;

3.2.2 Улс, нийслэл, орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө техникийн тодорхойлолт, ажлын даалгавар, зураг төсөв, бусад шаардлагатай бэлтгэл ажлыг Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 13 дугаар зүйл, Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйл, 29.4 дэх хэсэг, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор батлагдсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д нийцүүлж төлөвлөх; **(Төсвийн шууд захирагч нарт хамаарна)**

3.2.3 Хөрөнгө оруулалтын ажлын гэрээний үүргийн хэрэгжилтэд хяналт тавихдаа гэрээний үүргийн хуваарь, ажлын тоо хэмжээний дагуу ажлын гүйцэтгэл, чанарт байнгын хяналтыг тавьж, илэрсэн зөрчил, дутагдлыг тухай бүр арилгуулах арга хэмжээ авах, гэрээний үүргээ ноцтой зөрчсөн, биелүүлээгүй, эсхүл мэргэжлийн үйл ажиллагаанд алдаа гаргасан тохиолдолд уг аж ахуйн нэгж, байгууллагын талаарх мэдээллийг Төсвийн ерөнхийлөн захирагчид тайлагнаж ажиллах;

3.3 Өргөдөл, гомдол шийдвэрлэлтийн хүрээнд:

3.3.1 Засгийн газрын иргэд, олон нийттэй харилцах 11-11 төвд ирж байгаа өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийн байдлыг сайжруулж, иргэдээс харьяаллын дагуу ирсэн өргөдөл, гомдолд дурдсан асуудлыг эрх хэмжээнийхээ хүрээнд бүх талаас нь судлан үзэж, шуурхай, хуулийн хугацаанд, үндэслэлтэй хариу өгч, бүрэн барагдуулж шийдвэрлэх;

3.3.2 Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг бүртгэж, шилжүүлэх үйл явцын зөрчлийг арилгах, шат дамжлага, шийдвэрлэлтийн хугацааг бууруулах, шийдвэрлэлтийг сайжруулах чиглэлээр тусгай төлөвлөгөө боловсруулж, хэрэгжилтийг үр дүнтэй хангаж хугацааг 2 дахин бууруулах;

3.3.3 Иргэдийн өргөдөл, гомдлыг хуулийн хугацаанд шийдвэрлээгүй, шийдвэрлэх явцад ёс зүйн зөрчил гаргасан, тайлан мэдээг дээд шатны байгууллагад хугацаанд нь хүргүүлж ажиллаагүй албан тушаалтанд Төрийн албаны тухай хууль, Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуульд заасны дагуу хариуцлага тооцож, сахилга, хариуцлагыг чангатгах;

3.3.4 Иргэдээс гаргасан өргөдөл, гомдлыг бүрэн барагдуулж шийдвэрлэх, өмнөх оноос гомдлын тоог 30-иас доошгүй хувиар бууруулах;

3.3.5 Байгууллагуудын үйл ажиллагааны талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг мэргэжлийн байгууллагаар улирал бүр хийлгүүлж, дүнг үндэслэн цаашид авах арга хэмжээг төлөвлөн хэрэгжүүлэх.

3.4 Хотын хөгжлийн индексийн хүрээнд:

3.4.1 Засаг даргын Тамгын газар, Төлөвлөлт, гүйцэтгэлийн удирдлагын хэлтэстэй хамтран хотын хөгжлийн индексийн үзүүлэлтээс өөрийн байгууллагын хариуцах үзүүлэлтийн суурь түвшинг нягтлах, сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөө боловсруулах ажлыг 2024 оны 2 дугаар улиралд багтаан хийж гүйцэтгэх;

3.4.2 Хотын хөгжлийн индексийн өөрийн байгууллагын хамаарах үзүүлэлтийг сайжруулах үйл ажиллагааны төлөвлөгөөг хэрэгжүүлж, хүрсэн үр дүнг 2024 оны жилийн эцсийн байдлаар шинэчлэн тооцох ажлыг зохион байгуулах;

3.4.3 Хотын хөгжлийн индекс болон тухайн байгууллагын суурь мэдээллийг орон зайд суурилсан нийслэлийн дундын мэдээллийн санд тухай бүр оруулж ажиллах.

3.5 Хот нийтийн аж ахуйн хүрээнд:

3.5.1 “Тэрбум мод” үндэсний хөдөлгөөнийг хэрэгжүүлж (Засгийн газрын 2021 оны 350 дугаар тогтоол) өмнө жил тарьсан модоо арчилж тордох, дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээнд мод тарьж, ургуулах ажилд идэвхтэй оролцох,;

3.5.2 Нийслэл, дүүргээс зохион байгуулдаг хот, нийтийн аж ахуйн ажилд идэвхтэй оролцох, орчны 50 метр хүртэлх нийтийн эзэмшлийн зам, явган зам талбайг засварлах, цэвэрлэгээ үйлчилгээг тогтмол хийх, гадна тохижилт, хайс хашлага, хаягийн байгууламжийг стандартад нийцүүлэх;

3.6 Хотын стандартын хүрээнд:

3.6.1 Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн хүртээмжтэй байдлыг хотын стандартын дагуу хангуулах, байгууллагын гадна орчин, гудамж зам талбайг засварлаж, цэцэрлэгжүүлж, ногоон байгууламжтай болгон тохижуулах ажлыг зохион байгуулах;

3.6.2 Байгууллагын хэмжээнд хотын стандартыг мөрдүүлэх арга хэмжээний үр дүнг дүүргийн Засаг даргын Тамгын газрын Тохижилт, нийтийн аж ахуйн хэлтэст 2024 оны эхний хагас жилд багтаан танилцуулж, тайлагнах;

3.7 Бусад:

3.7.1 Энэхүү гэрээний 5.2, 5.3-т заасан хугацаанд гэрээний хэрэгжилтийн тайланг ирүүлэх;

3.7.2 Төрийн байгууллагын үйл ажиллагааны нээлттэй, ил тод байдлыг нэмэгдүүлж, хүнд суртлыг багасгах, авлига үүсэх эрсдэлийг бууруулах;

3.7.3 Төрийн албан хаагчийг томилохдоо “Төрийн албан тушаалд шатлан дэвшүүлэх журам”, “Төрийн жинхэнэ албан хаагчийг өөр албан тушаалд шилжүүлэх, сэлгэн ажиллуулах журам”-ын зохицуулалтын дагуу зохист хэлбэрүүдийг ашиглан хууль зөрчихгүй ажиллана. Хууль зөрчсөн тохиолдолд Төрийн албаны тухай хуульд заасны дагуу хариуцлага хүлээх;

3.7.4 Төрийн албаны хүний нөөцийг чадавхжуулах чиглэлээр үр дүнтэй арга хэмжээг хэрэгжүүлэх, төрийн албан хаагчийн үйл ажиллагааг үнэлэхдээ ажлын гүйцэтгэл, ёс зүй, сахилга хариуцлагыг шалгуур болгох;

3.7.5 Төрийн цаасан суурьтай үйл ажиллагааг багасган цахим хэлбэрт шилжүүлж, төрийн үйлчилгээний шат дамжлагыг багасгах, чанар, хүртээмжийг сайжруулах;

3.7.6 Архив, албан хэрэг хөтлөлтийн тухай хуулийн хэрэгжилтийг байгууллагын хэмжээнд хэрэгжүүлэх;

3.7.7 Дүүргийн удирдах ажилтны шуурхай зөвлөгөөнд тухай бүр оролцож, өгөгдсөн үүрэг даалгаврыг хугацаанд нь чанартай гүйцэтгэж тухай бүр тайлагнах;

3.7.8 Байгууллагын 2023 оны үйл ажиллагааны үр дүнд үнэлгээ өгсөн ажлын хэсгээс хүргүүлсэн зөвлөмж, дүгнэлтэд тусгасан ажлыг тусгай төлөвлөгөө гарган хэрэгжүүлж хагас, бүтэн жилээр тайлангийн хамт, үр дүнг нь үнэлэн дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт, шинжилгээ, үнэлгээний хэлтэст ирүүлэх;

Дөрөв. Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Нийслэлийн хөгжлийн 2022 оны төлөвлөгөө, дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх

4.1 Дүүргийн Засаг даргын 2021-2024 онд хэрэгжүүлэх “Эко-Эрүүл дүүрэг” үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд тусгагдсан зорилт, арга хэмжээг чиг үүргийн хүрээнд зохион байгуулж, биелэлтийг улирал бүр,

4.2 Нийслэлийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, “Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын Захирагчийн 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”, нийслэлийн хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнөөс холбогдох арга хэмжээний хэрэгжилтийг ханган улирал бүр,

4.3 Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн 2024 оны төлөвлөгөөнд тусгасан холбогдох зорилт, арга хэмжээний биелэлтийг сар бүр, Засгийн газрын 2020 оны 206 дугаар тогтоолоор батлагдсан журмын 3б, 3в хавсралтын дагуу боловсруулж, дүүргийн Засаг даргын Тамгын газрын Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэст хугацаанд нь тайлагнана.

Тав. Гэрээний хэрэгжилтийг тайлагнах, гэрээг дүгнэх

5.1 Энэхүү гэрээний хэрэгжилт хангагдсан эсэхийг үнэлэхдээ Төрийн албаны тухай хууль, Төсвийн тухай хууль болон тухайн салбарт мөрдлөг болгож буй хууль, дүрэм, журам, заавар стандарт, нормыг үндэслэл болгоно.

5.2 Гэрээний биелэлтийн хагас жилийн тайланг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрийн дотор, бүтэн жилийн тайланг 2024 оны 12 дугаар сарын 01-ны өдрийн дотор дүүргийн Засаг даргын Тамгын газарт ирүүлнэ.

5.3 Санхүүгийн хагас жилийн тайланг Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасан хугацааны дотор батлагдсан заавар, журмын дагуу гаргаж, хөтөлбөрийн үр дүнгийн тайлангийн хамт төсвийн ерөнхийлөн захирагчид хүргүүлнэ. **(Төсвийн шууд захирагчид хамаарна)**

5.4 Гэрээний биелэлт үр дүнгийн тайланг дүүргийн Засаг дарга үнэлнэ. Ингэж үнэлэхдээ дүүргийн Засагдаргын Тамгын газрын нэгжийн ажилтнуудыг хамруулан оролцуулж тайланг дүгнэнэ.

5.5 Гэрээний хэрэгжилтийн үр дүн, тоо хэмжээ, чанарыг энэхүү гэрээний 5.1-д заасныг удирдлага болгон үнэлнэ.

5.6 Шаардлагатай бол тусгайлсан мэргэжлийн байгууллагаар үнэлгээ хийлгэнэ.

Зургаа. Гэрээний хугацаа

6.1 Энэхүү гэрээний нийт хугацаа төсвийн жилийн хугацаанд үйлчилнэ.

Долоо. Гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах, гэрээг цуцлах

7.1 Гэрээний оролцогч талууд бичгээр санал тавьж, харилцан зөвшилцөн гэрээнд нэмэлт, өөрчлөлт оруулах болон цуцалж болно.

7.2 Гэрээнд тусгагдаагүй асуудлыг талууд харилцан зөвшилцөж, хууль, тогтоомжид нийцүүлэн нэмэлт гэрээ байгуулах замаар шийдвэрлэж болно.

Найм. Гэрээний урамшуулал ба хариуцлага

8.1 Хэлтэс, албаны дарга нь гэрээгээр хүлээсэн үүргээ хангалттай биелүүлсэн тохиолдолд ажлын үр дүнгээс хамаарч урамшуулал олгох асуудлыг төсвийн ерөнхийлөн захирагч холбогдох хууль тогтоомжийн дагуу шийдвэрлэнэ.

8.2 Засаг даргын дэргэдэх хэлтэс, албаны дарга нь гэрээгээр хүлээсэн үүргээ зөрчсөн болон хангалтгүй биелүүлсэн, Төрийн албан хаагчийн ёс зүйн хэм хэмжээг зөрчсөн тохиолдолд Төсвийн ерөнхийлөн захирагч түүнд Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Авлигын эсрэгхууль, Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль болон бусад хууль, тогтоомжид заасан хариуцлагыг хүлээлгэнэ.

Ес. Гэрээ хүчин төгөлдөр болох

9.1 Энэхүү гэрээ нь талууд гарын үсэг зурж тамга дарж баталгаажуулснаар хүчин төгөлдөр болно.

ТӨСВИЙН ЕРӨНХИЙЛӨН ЗАХИРАГЧ:
ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГА

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ:
АЛБАН БУС, НАСАН ТУРШИЙН
БОЛОВСРОЛЫН ТӨВИЙН ЗАХИРАЛ

ЖУКОВЫН АЛДАРЖАВХЛАН

ТАНШИЙГИЙН РЭГЗЭДМАА